

МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 7 сарын 1 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” (цаашид “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” гэх)-т доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг:

“18.8. ТШЗ-ны 18.2-т зааснаар ирүүлсэн барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь ТШЗ-ны 30 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 18.3-т заасан үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт:

“21.5.3. санал болгож буй бараа техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 17.4-т зааснаар тайлбарласан тайлбар;”

3/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт:

“5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.”

2. Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг” (цаашид “Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг” гэх)-т доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг:

“17.7. ТШЗ-ны 17.2-т зааснаар ирүүлсэн төсвийн нийт нийлбэр нь ТШЗ-ны 30 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 17.3-т заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 20 дугаар зүйлийн 20.5.3 дахь заалт:

“20.5.3. санал болгож буй ажил техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 16.2-т зааснаар тайлбарласан тайлбар;”

3/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт:

“8.1.6. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.”

3. Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичиг” (цаашид “Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичиг” гэх)-ийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгаанд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг:

“17.7. ТШЗ-ны 17.2-т зааснаар ирүүлсэн үйл ажиллагааны хуваарийн нийт нийлбэр нь ТШЗ-ны 29 дүгээр зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 17.3-т заасан үнээс зөрүүтэй бол үйл ажиллагааны хуваарийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ 20 дугаар зүйлийн 20.5.3 дахь заалт:

“20.5.3. санал болгож буй үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 16.2-т зааснаар тайлбарласан тайлбар;”

4. Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан тендерийн жишиг баримт бичгүүдийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэг:

“21.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр илгээнэ.”

2/ Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг:

“20.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр илгээнэ.”

3/ Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг:

“20.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр илгээнэ.”

4/ Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг:

“24.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

24.5.1. ТШЗ-ны 18.8-д зааснаар барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

24.5.2. ТШЗ-ны 29 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

24.5.3. ТШЗ-ны 30 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

5/ Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг:

“23.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

23.5.1. ТШЗ-ны 17.7-д зааснаар төсвийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

23.5.2. ТШЗ-ны 28 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

23.5.3. ТШЗ-ны 29 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

6/ Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг:

“23.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

23.5.1. ТШЗ-ны 17.7-д зааснаар үйлчилгээний үнийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

23.5.2. ТШЗ-ны 28 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

23.5.3. ТШЗ-ны 29 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

5. Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэг, Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг

баримт бичгийн I бүлгийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийн “мөнгөн” гэснийг “түргэн хөрвөх” гэж, Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн 21.5.3 дахь заалтын дугаарыг “21.5.4” гэж, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн 20.5.3 дахь заалт болон Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн 20.5.3 дахь заалтын дугаарыг “20.5.4” гэж, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн VI бүлгийн “Урьдчилгаа төлбөрийн баталгаа (Банкны баталгаа)”, “Урьдчилгаа төлбөрийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)”-ны маягтуудын “Гүйцэтгэлийн” гэснийг “Урьдчилгаа төлбөрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

6. Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 5, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 5-ыг энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар, Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 6-г энэ тушаалын 2 дугаар хавсралтаар тус тус нэмсүгэй.

7. Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн VI бүлгийн Гэрээ баталгаажуулах маягыг 3 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

8. Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийн V бүлгийн Маягт 4, Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 4, Харьцуулалтын аргаар зөвлөхөөс бусад үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 5-ын хүснэгтүүдийн 8 дугаар мөрийг тус тус хассугай.

Б.ЖАВХЛАН

**Маягт 5      Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---------------------------------------------|--------------------------------------|
| 1. |                                             |                                      |
| 2. |                                             |                                      |
| 3. |                                             |                                      |
| 4. |                                             |                                      |
| 5. |                                             |                                      |

**Маягт 6      Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---------------------------------------------|--------------------------------------|
| 1. |                                             |                                      |
| 2. |                                             |                                      |
| 3. |                                             |                                      |
| 4. |                                             |                                      |
| 5. |                                             |                                      |

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

**[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ**  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчээс ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг нийлүүлэгч .....-ийн харилцах .....банкны ..... дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  2. Гэрээ баталгаажуулах маягт;
  3. Гэрээний тусгай нөхцөл;
  4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  5. Техникийн тодорхойлолт;
  6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх/ -ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх/-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 7 сарын 1 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2021 оны 144 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” (цаашид “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг” гэх)-т доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэг:

“20.8. ТШЗ-ны 20.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь ТШЗ-ны 33 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 20.3-т заасан үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 24 дүгээр зүйлийн 24.5.3 дахь заалт:

“24.5.3.санал болгож буй бараа техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 19.4-т зааснаар тайлбарласан тайлбар;”

3/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт:

“5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.”

2. Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1. Захиалагч ТШЗ-ны 2.1-д заасан төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон тендерийн баталгаа ирүүлэхийг ТӨХ-д заана. Тендерт оролцогч тухайн үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй үүрэг гүйцэтгэх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан ирүүлнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг:

“24.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 8-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.”

3/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 27.5 дахь хэсэг:

“27.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

27.5.1. ТШЗ-ны 20.8-д зааснаар барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

27.5.2. ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

27.5.3. ТШЗ-ны 33 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

4/ II бүлгийн Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 23.1:

“ТШЗ 23.1 Тендерийн баталгааны дүн: *[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц тус бүрээр доорх байдлаар заана:*

*Багц №1: [●] төгрөг;*

*Багц №2: [●] төгрөг.]”*

5/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлийн 2.19 дэх хэсэг:

“2.19. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.”

6/ VI бүлгийн Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны), Гүйцэтгэлийн баталгааны маягт (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)-ын 5, 6 дугаар зүйл:

“5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэлх хугацаанд хүчинтэй байна:

5.1. төсвийн жил дамжин гүйцэтгэх гэрээний шинэчилсэн гүйцэтгэлийн баталгааг захиалагч хүлээн авсан; эсхүл

5.2. гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.

6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.”

3. Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсгийн “мөнгөн” гэснийг “түргэн хөрвөх” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5.3 дахь заалтын дугаарыг “24.5.4” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “гэрээний үнийн 5 хувийн” гэснийг “тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлэгт Маягт 8-ыг энэ тушаалын хавсралтаар нэмсүгэй.

5. Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 7-ийн хүснэгтийн 8 дахь мөрийг хассугай.

**Б.ЖАВХЛАН**

**Маягт 8      Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---------------------------------------------|--------------------------------------|
| 1. |                                             |                                      |
| 2. |                                             |                                      |
| 3. |                                             |                                      |
| 4. |                                             |                                      |
| 5. |                                             |                                      |

МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 7 сарын 1 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2021 оны 145 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг” (цаашид “Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичиг” гэх)-т доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэг:

“19.7. ТШЗ-ны 19.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь ТШЗ-ны 32 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 19.3-т заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 23 дугаар зүйлийн 23.5.3 дахь заалт:

“23.5.3.санал болгож буй ажил техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 18.2-т зааснаар тайлбарласан тайлбар;”

3/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалт:

“9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.”

2. Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1. Захиалагч ТШЗ-ны 2.1-д заасан төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон тендерийн баталгаа ирүүлэхийг ТӨХ-д заана. Тендерт оролцогч тухайн үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй үүрэг гүйцэтгэх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан ирүүлнэ.”

“23.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 9-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.”

3/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 26.5 дахь хэсэг:

“26.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

25.5.1. ТШЗ-ны 19.7-д зааснаар эрх бүхий этгээдийн тооцсон төсвийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

26.5.2. ТШЗ-ны 31 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

26.5.3. ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

4/ II бүлгийн Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 22.1:

“ТШЗ 22.1 Тендерийн баталгааны дүн: *[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц тус бүрээр доорх байдлаар заана:*

*Багц №1: [●] төгрөг;*

*Багц №2: [●] төгрөг.]”*

5/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 6.2 дахь хэсэг:

“6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.”

6/ VI бүлгийн Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны), Гүйцэтгэлийн баталгааны маягт (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)-ын 5, 6 дугаар зүйл:

“5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэл хугацаанд хүчинтэй байна:

5.1. төсвийн жил дамжин гүйцэтгэх гэрээний шинэчилсэн гүйцэтгэлийн баталгааг захиалагч хүлээн авсан; эсхүл

5.2. гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.

6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.”

3. Сангийн сайдын 2021 оны 145 дугаар тушаалын 2 болон 4 дэх заалтын “бараа” гэснийг “ажил” гэж, Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсгийн “мөнгөн” гэснийг “түргэн хөрвөх” гэж, 23 дугаар зүйлийн 23.5.3 дахь заалтын дугаарыг “23.5.4” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “гэрээний үнийн 5 хувийн” гэснийг “тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн” гэж, VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “дуусч” гэснийг “дуусаж” гэж, 10 дугаар

зүйлийн 10.8 дахь хэсгийн “санаачлагаар” гэснийг “санаачилгаар” гэж, 10.23 дахь хэсгийн “хамгаалалтанд” гэснийг “хамгаалалтад” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 8-ын хүснэгтийн 8 дахь мөрийг хассугай.

5. Ажил гүйцэтгүүлэх тендерийн жишиг баримт бичгийн V бүлэгт Маягт 9-ийг энэ тушаалын хавсралтаар нэмсүгэй.

6. Сангийн сайдын 2013 оны 290 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

**Б.ЖАВХЛАН**

**Маягт 9      Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---------------------------------------------|--------------------------------------|
| 1. |                                             |                                      |
| 2. |                                             |                                      |
| 3. |                                             |                                      |
| 4. |                                             |                                      |
| 5. |                                             |                                      |



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 7 сарын 1 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2021 оны 146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичиг” (“Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичиг” гэх)-ийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгаанд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэг:

“19.7. ТШЗ-ны 19.2-т зааснаар ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт жагсаасан үйлчилгээний нийт нийлбэр нь ТШЗ-ны 32 дугаар зүйлд заасан арифметик алдаагүй боловч ТШЗ-ны 19.4-т заасан үнээс зөрүүтэй бол үйл ажиллагааны хуваарийн нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзнэ.”

2/ 23 дугаар зүйлийн 23.5.3 дахь заалт:

“23.5.3.санал болгож буй үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцэх эсэхийг ТШЗ-ны 18.2-т зааснаар тайлбарласан тайлбар;

2. Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1. Захиалагч ТШЗ-ны 2.1-д заасан төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон тендерийн баталгаа ирүүлэхийг ТӨХ-д заана. Тендерт оролцогч тухайн үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй үүрэг гүйцэтгэх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан ирүүлнэ.”

2/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэг:

“23.7. Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 9-ийн дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.”

3/ I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:

“26.5. Доор дурдсанаас бусад тохиолдолд тендерийн нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй:

26.5.1. ТШЗ-ны 19.7-д зааснаар барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендерийн үнэ гэж үзэх;

26.5.2. ТШЗ-ны 31 дүгээр зүйлд зааснаар тендерийн үнийг нэг валютад хөрвүүлэх;

26.5.3. ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар тендерийн үнийн арифметик алдааг залруулах.”

4/ II бүлгийн Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 22.1:

“ТШЗ 22.1 Тендерийн баталгааны дүн: *[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож заах ба багцтай бол багц тус бүрээр доорх байдлаар заана:*

*Багц №1: [●] төгрөг;*

*Багц №2: [●] төгрөг.]”*

5/ VI бүлгийн Гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлийн 2.17 дахь хэсэг:

“2.17. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Үйлчилгээ үзүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.”

6/ VI бүлгийн Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны), Гүйцэтгэлийн баталгааны маягт (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)-ын 5, 6 дугаар зүйл:

“5. Энэхүү баталгаа нь захиалагчийн дараах мэдэгдлийг ирүүлэх хүртэл хугацаанд хүчинтэй байна:

5.1. төсвийн жил дамжин гүйцэтгэх гэрээний шинэчилсэн гүйцэтгэлийн баталгааг захиалагч хүлээн авсан; эсхүл

5.2. гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дууссаныг захиалагч хүлээн зөвшөөрсөн.

6. Энэхүү баталгааг хүчингүй болгоход зөвхөн захиалагчийн зөвшөөрлийг үндэслэх ба бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.”

3. Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн I бүлгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсгийн “мөнгөн” гэснийг “түргэн хөрвөх” гэж, 23 дугаар зүйлийн 23.5.3 дахь заалтын дугаарыг “23.5.4” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “гэрээний үнийн 5 хувийн” гэснийг “тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлгийн Маягт 8-ын хүснэгтийн 8 дахь мөрийг хассугай.

5. Зөвлөхийн бус үйлчилгээ авах тендерийн жишиг баримт бичгийн V бүлэгт Маягт 9-ийг энэ тушаалын хавсралтаар нэмсүгэй.

**Б.ЖАВХЛАН**

**Маягт 9      Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

|    | <b>Нууцалсан баримт бичиг,<br/>мэдээлэл</b> | <b>Нууцалсан хууль зүйн үндэслэл</b> |
|----|---------------------------------------------|--------------------------------------|
| 1. |                                             |                                      |
| 2. |                                             |                                      |
| 3. |                                             |                                      |
| 4. |                                             |                                      |
| 5. |                                             |                                      |